



ХЭНГИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 5/02

Чингис хот

Ц.Цэрэндоржид сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.4, 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.1, 26.3 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам"-ын 3, 4, 5-ын "а", 6, "Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам"-ын 9.1, 10.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн Ц.Цэрэндорж нь хүндэтгэх шалтгаангүйгээр 1 дүгээр сарын 11-ний 10:00-17:00 цагийн хооронд ажлын 6 цаг тасалсан тул сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

Хоёр. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ц.Цэрэндоржид үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

03 012